

**ШИНЭЖИНСТ СУМЫН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ
ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2024 оны 11 дүгээр сарын 25

Залаа

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Биелэлт
1	2	3	4
Нэг. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр			
1	Иргэдэд Эрүү шүүлт тулгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийх	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулсан байна	Гэмт хэрэг зөрчлөөс ангид байх хүрээнд цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням Эрүүгийн тухай болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын талаар иргэдэд сургалтыг 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар иргэд, төрийн албан хаагчид орсон. Мөн 11 дүгээр сарын 25-нд Шинэжинст сумын Сум дундын Цагдаагийн тасгийн дарга Хурандаа Б.Алтангэрэл нийт төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл өгч ажилласан.
Хоёр. Хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр			
2	Ахмад настны эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтэд насжилтын талаар зэрэг хандлага, зан байдлыг бий болгох, ахмад настныг нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Ахмад настан, олон нийтэд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.	Ахмад настангуудад Ахмад настны тухай хуулиар Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн 1 удаа, насжилтын зөрүүг арилгаж, зэрэг хандлага, зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх сэдвүүдээр Нийгмийн бодлогын мэргэжилтэн 1 удаа тус тус сургалт хийж нийт 50 ахмад настан хамрагдсан

1	2	3	4
3	Хүүхдийн тоглоомын талбайд Монгол улсын стандарт MNS6751:2019 хэрэгжилтийг хангаж буй эсэхэд хяналт тавьж холбогдох арга хэмжээг авах	Хүүхдийн тоглоомын талбайд шалгалт явуулж стандартад нийцүүлэн шинэчилж засварласан байна	Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайн гадаргуун хэсгээс бусад нь стандартын дагуу хийгдсэн стандартын зүлэгжүүлэлт гадаргууг хийхээр төлөвлөн санхүүг шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. Сургууль стандартын тоглоомын талбай байхгүй. Дотоод хяналтын хүрээнд хяналтын хуудсаар үнэлдэг боловч сайжруулах засварлах төсөв хөрөнгө байхгүй. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн саналд оруулсан боловч дэмжигдээгүй. Засаг даргын тамгын газраас орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сумын төвд нийтийн биеийн тамирын талбайг байгуулан стандартад нийцсэн хүүхдийн тоглоомын тайлбайг бай байгаа бөгөөд ажлын гүйцэтгэл 90%-тай байна.
4	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг Хөдөлмөр эрхлэлтийн сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх	Арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 107 иргэнд 26451585 төгрөг, - Өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 9 иргэнд 5512088 төгрөг, - Жирэмсэн эхийн тэтгэмж 12 иргэнд 2411123 төгрөг ажилласан. - Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 1011 хүүхдэд 517 сая төгрөг олгож ажилласан. Эмэгтэйчүүдийн ажлын байрыг дэмжиж сумын хэмжээнд нийт 6 эмэгтэйд 22 сая төгрөгийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгосон.
5	Төрийн албан хаагчдын жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх мэдээлэл, сургалт зохион байгуулах	Сургалтад удирдах албанд 75 хувь, төрийн албан хаагч 85 хувь хамрагдсан байна.	“Жендерийн эрх тэгш байдлын талаарх ойлголт” сургалтыг 11 сарын 18-нд нийт төрийн албан хаагчдад орсон бөгөөд сургалтад бүх төрийн албан хаагч буюу 85 нь албан хаагч хамрагдсан.

1	2	3	4
6	“Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласан. Жендэрийн эрх тэгш байдлын талаарх иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Ажлын байрны бэлгийн дарамт түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалтыг төрийн албан хаагчдын мэдээллийн цагаар зохион байгуулсан. Мөн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд эмэгтэйчүүдийн төлөөлөл 30 хувь байна.
7	Хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтэд зөв эерэг ойлголт хандлага өгөх нөлөөллийн ажил зохион байгуулах	Олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна.	ХБИ-ын дунд софт волейболын тэмцээн, даам, шатарын тэмцээн зохион байгуулан ажиллаа. Софт волейболын тэмцээнд нийт 7 баг буюу 28 хүн оролцлоо. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх үүргийн талаар ХБИ-ийн хөтөлбөр хариуцсан эмч Д.Нямцэрэн сургалт хийж мэдээлэл өгсөн. Сургалтанд 17 иргэн хамрагдсан.
8	Нэг цэгийн үйлчилгээний газруудад ахмад настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ байрлуулж дугаар харгалзахгүй үйлчилгээ үзүүлж хэвших	Тэмдэг тэмдэглэгээ байршуулан үйлчилгээ үзүүлж хэвшсэн байна.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс замын хаалт, тэмдэг 16 ширхэгийг хийсэн. Мөн ЕБСургууль, сумын хамтарсан багтай хамтран сургуулийн хүүхдүүдэд зориулсан зурган тэмдэглэгээ хийлгэх ажлыг төлөвлөөд ИТ хуралд танилцуулаад, Дурсамж принт ХХК-д захиалгаа хүргүүлсэн байна. Мөн нэг цэгийн үйлчилгээний газруудад ахмад настан, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үйлчлэх тэмдэг, тэмдэглэгээ

1	2	3	4
			байрлуулах ажлыг ИТХ-д танилцуулахаар мэдээг танилцуулсан
9	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хүргэх боловсролын үйлчилгээг нэмэгдүүлж хөгжлийг дэмжсэн арга хэмжээ зохион байгуулах\танхимын танхимын бус\	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд бүрэн хамруулж тусгай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж хөгжлийг нь дэмжсэн ажил зохион байгуулсан байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд манай сумд нийт 7 байдаг. Үүнээс өдрийн ангиудад 5 суралцагч сууж байна. Сургуулийн гадна 2 хүүхэд байдаг. Танхимаар 5 суралцагчийн АУБ нарт 10 хувийн нэмэгдэл өгч ажиллаж байна. Энэ багш нар шат дараатай цахим болон танхимын сургалтад суудаг.
Гурав. Гэр бүлийн болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр			
10	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийг иргэдэд сурталчилан танилцуулах	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийн хохирсон талаар болон бусад мэдээлэл хамгаалагдсан байна.	Гэр бүлийн хүчирхийлэл болон бусад холбогдох эрх зүйн сургалтыг мэдээллийн цагаар 5 удаа зохион байгуулсан. Үүнд: Хүүхэд хамгааллын эрх зүйн орчны шинэчлэл сэдвээр ХГБХХГ-аас, Гэр бүлийн хүчирхийлэл, Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрх, Хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга, хүүхдийн эрх үүрэг зэрэг хуулиар нийт 505 иргэнд сургалт мэдээлэл өгсөн байна.
11	Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах	Хамтарсан багийн гишүүд 100 хувь хамрагдсан байна	Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газраас 4 дүгээр сард нэг удаа Хүүхэд хамгааллын эрх зүйн орчны шинэчлэл, үе тэнгийн дээрэлхэлт, өвсөр үеийн охидын эрүүл мэнд зэрэг сэдвүүдээр, нийгмийн бодлогын мэргэжилтэнд кейс бүрдүүлэлтийн чиглэлээр сургалт зөвлөгөө өгч ажилласан. Мөн аймагт болсон Монгол өрх сэтгэл зүйн нийгэмлэгээс зохион байгуулсан Кейс дээр ажиллах арга зүй, хүүхдийн сэтгэл зүйн онцлог чиглэлээр сургалтад

1	2	3	4
			сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн нар хамрагдсан.
12	Гэр бүлийн харилцаа, хүчирхийлэл, гэр бүлийн эрх зүйн талаар мэргэжлийн сэтгэл зүйчийг урьж сургалт, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Сургалтад иргэдийн 10-оос доошгүй хувь хамрагдсан байна	Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн сэтгэл зүйч Г.Бандицэрэнг урьж “Амьдралын үнэ цэн” сэдэвт гэр бүлийн сэтгэл зүйн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж 125 иргэд, 246 сурагчид хамрагдсан. Сэтгэл зүйч Г.Бандицэрэн нь сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг 6 иргэнд өгч ажилласан.
Дөрөв. Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр			
13	Сургууль завсардалт, завсардаж болзошгүй хүүхдүүдийг илрүүлэн судалж сургуульд бүрэн хамруулах	Сургууль завсардалтгүй байна.	Сургууль завсардалт байхгүй. Хамран сургах тойргийн хүүхдүүд ЕБС д бүрэн хамрагдаж байгаа.
14	Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын төлөвлөлтийг сайжруулж биелэлтийг тайлагнах	Зөвлөлийн ажил биелсэн байна.	Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын төлөвлөлтийг сайжруулахад анхаарч ажиллаж байна. Энэ оны биелэлтийг тооцоох хугацаа болоогүй байна.
15	Сургуулийн дотуур байрыг шинээр барих засварлах ажлын зураг төсвийг төлөвлөн шийдвэрлэх	Зураг төсөв хийгдсэн байна.	Сургуулийн дотуур байрыг шинээр барих, засварлах ажлын зураг төсвийг хийгэсэн боловч улсын төсөвт сууж төсөв шийдэгдээгүй. 1-р тойргоос сонгогдсон их хурлын гишүүд болон боловсролын газрын даргад нөхцөл байдлыг танилцуулж хамтран ажиллах албан бичиг хүргүүлсэн. 2025 оны төсвийн цахим саналын жагсаалтад орж иргэд цахимаар санал өгсөн.
16	Их дээд сургуульд тэргүүлэх чиглэлээр суралцаж буй оюутнууд, тусгай хэрэгцээт, эмзэг бүлгийн суралцагч оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах	Оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн байна.	Төсөв санхүүтэй холбоотойгоор хүлээгдэж байна.

1	2	3	4
17	Эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд тохирсон боловсролын үйлчилгээ үзүүлэх	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж эцэг эхийн оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн байх	Эрүүл мэндийн шалтгаанаар сургуулийн гадна 2 хүүхэд байдаг. Энэ 2 хүүхдэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгийн дагуу НТСНБагш сард нэг удаа асран хамгаалагч нартай хамтарч өөрийн сэтгэхүй онцлогт нь таарсан бие даалтыг өгч ажилдаг. Энэ 2 хүүхэд хэвтрийн тул биеэ даах чадвар байхгүй. нэг удаа асран хамгаалагч нартай хамтарч өөрийн сэтгэхүй онцлогт нь таарсан бие даалтыг өгч ажилдаг. Энэ 2 хүүхэд хэвтрийн тул биеэ даах чадвар байхгүй.
18	Сурагчдын дунд цахим орчны зохистой хэрэглээний талаар уралдаан, мэтгэлцээн зэрэг арга хэмжээ зохион байгуулах	Уралдаан, мэтгэлцээн зохион байгуулсан байна.	Сурагчдын дунд Аутизм, Усны өдрийн постерийн уралдаан, Авлигын эсрэг гэрэл түгээе аянг тус тус амжилттай зохион байгуулан шагнал байранд шалгарсан сурагчдыг шагнаж урамшуулсан нийт 53 сурагч оролцсон байна.
19	“Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	2024 оны жилийн эцсийн байдлаар жирэмсний хяналтанд нийт 31 жирэмсэн орсоноос эхний гурван сартайн хяналт 27 буюу 87 хувьтай байна.Жирэмсэн эмэгтэйчүүдийн сургалтыг нийт 6 удаа зохион байгуулсан. Сургалтанд давхардсан тоогоор нийт 67 жирэмсэн , ар гэр нийт 85 хүн хамрагдсан.Мөн сумыхаа жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулж тэдний санал бодолыг хуваалцах

1	2	3	4
			мэдээлэл хүргэх, сургалт явуулах зорилготой facebook групп, Messenger нээж ажиллуулж байна. 2024 онд 11 жирэмсэн эхийг аймгийн нэгдсэн эмнэлэгт төрүүлхээр шилжүүлсэн. Шинээр хяналтанд орж буй жирэмсэн эмэгтэйчүүдэд элэний В,С вирусын шинжилгээнд 100% хамруулсан. 31 эмэгтэй хамрагдсан. В вирустэй 1 жирэмсэн хянагдаж байгаа. Шинээр хяналтанд орж буй жирэмсэн эмэгтэйчүүдийг тэмбүүгийн шинжилгээнд 100% хамруулсан. Шинэ өвчлөл илрээгүй.
20	Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга барилд залуу эцэг эхчүүдийг дадлагажуулах сургалт арга хэмжээ зохион байгуулах	Үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	Сургууль, эцэг эх асран хамгаалагч нарын уялдаа холбоог сайжруулах зорилготой уулзалт өртөөчилсөн сургалт зохион байгуулж нийт 190 эцэг эх асран хамгаалагч оролцсон. ГБХЗХХ-ийн газрын хүмүүжлийн эерэг арга сургалт 2 удаа эцэг асран хамгаалагч нарт орсон. Нийт 220 эцэг эх хамрагдсан.
	Холбогдох салбарын албан хаагчид, хохирогчид үйлчилгээ үзүүлдэг нийгмийн ажилтануудыг мэргэшүүлэх, давтан сургах сургалтад хамруулах	Сургалтад хамрагдсан байна	Аймгийн ГБХЗХХ-ийн газраас зохион байгуулсан нийгмийн ажилтануудыг чадавжуулах сургалтанд 2 удаа хамрагдсан.
21	Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг сурталчилан таниулах үйл ажиллагаа зохион байгуулах	Сурталчилан таниулах үйл ажиллагаа зохион байгуулсан байна.	9 дүгээр сард сургалт хийхээр төлөвлөсөн байна.
22	Хүүхэд хамгааллын төлөвлөгөө хэрэгжүүлж биелэлтийг тайлагнах	Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна.	Сар бүрийн сүүлийн долоо хоногийг багш айлчлалын долоо хоног болгон зарлаж Анги удирдсан багш нар нийт сурагчдын


1	2	3	4
			70% аар айлчлал хийн сурагчдын амьдрах орчин, эрүүл аюулгүй орчинд хичээл хийх таатай орчин бүрдсэн талаар судлан ажиллаж байна. Сургуулийн хүүхэд хамгааллын багаас сумын Хамтарсан багт өрх толгойлон амьдарч буй сурагчид, гэмт хэрэгт өртөж болзошгүй сурагчдын судалгаа гарган өгч Сумын хамтарсан баг оройн 19:00 цагаас 22:00 цаг хүртэл эргүүлд гаран ажиллаж байна. Хүүхэд хамгааллын баг нэг өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн Мөн сумын Хамтарсан багт өрх толгойлон амьдарч буй сурагчид гэмт хэрэгт өртөж болзошгүй 12 сурагчдын судалгааг гарган өгч оройн цагаар гэр айлчлал хийн ажилласан. Хүүхдээ сонсох өдрийг улиралд нэг удаа зохион байгуулж сурагчид тулгамдаж буй асуудлын талаар судалгаа гарган Сумын хамтарсан багт хүргэн ажилладаг. Хүүхдийн чуулганыг нэг удаа зохион байгуулж Сумын хамтарсан багийн ахлагч Б.Батэрдэнэ, Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн Ш.Даваацэрэн нар оролцож Хүүхдийн эрх, соёл спорт олон нийтийн ажилд оролцох журмын талаар мэдээлэл өгсөн нийт 120 сурагч оролцсон.
Тав. Ялгаварлан гадуурхах хэлбэр, тэр дундаа ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр			
23	Залуучуудын хөгжил оролцоог дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээнд бэлгийн чиг хандлагын талаарх зөв ойлголт, ялгаварлан гадуурхалтын эсрэг агуулгыг тусгаж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах	Сургалт, нөлөөллийн арга хэмжээний агуулгад тусгасан байна.	Өсвөр үеийн охидод нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр насны онцлог, сарын тэмдэгийн эрүүл ахуй зэрэг сэдвүүдээр эх баригч Д.Бадамсүрэн сургалт хийсэн. Сургалтанд ахлах ангийн 87 эмэгтэй сурагчид хамрагдсан.


1	2	3	4	5
24	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг иргэд, төрийн албан хаагч нарт мэдлэг, ойлголт өгөх сургалт сурталчилгааны ажил зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.	10 дугаар сард хийгдэхээр хүлээгдэж байна.	
Зургаа. Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх эрхийг хангах чиглэлээр				
25	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, тайлан	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМГ-луу хагас жилээр тайлан мэдээ явуулсан. Хөх умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгт тухайн онд 159 эмэгтэй хамрагдахаас одоогийн байдлаар 76 эмэгтэй хамрагдсан. Хамрагдалтын хувь 47,7% байна. 7-9 дүгээр ангийн охидуудад “БЗДХ-с сэргийлэх”, “Хүсээгүй жирэмслэлт” “Сарын тэмдэгийн үеийн эрүүл ахуй сэдвүүдээр сургалт зөвлөгөө зохион байгуулж ажиллсан. Нийт 75 сурагч хамрагдсан.	
26	Эмч, эмнэлэгийн байгууллагын ажилтан нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлага, ойлголтыг сайжруулах, тэдэнд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Арга хэмжээ зохион байгуулсан байна.	Эмч эмнэлгийн байгууллагын ажилтан нарын хөгжлийн бэрхшээлийн талаарх хандлага ойлголтыг сайжруулах, тэдний талаар зөв ойлголттой болгох үүднээс сургалт зохион байгуулсан. Сургалтанд 18 эмч, ажилчид хамрагдсан. Хөгжлийн бэрхшээлтэй болон сэтгэцийн эмгэгтэй иргэдийг хүйсийн тэнцвэрт байдлаар нь харьцуулан хувааж сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж байна. Сургалтанд 21 иргэн, арга хэмжээнд 44 иргэн хамрагдсан	

1	2	3	4
27	Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн хор уршиг, гэр бүл төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгуулах, мэдээлэл сургалт сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулсан байна.	Хүсээгүй жирэмслэлт үр хөндөлтийн хор уршиг гэр бүл төлөвлөлтийн ач холбогдлыг ойлгуулах чиглэлийн сургалтыг өсвөр үеийнхэн, залуучуудад хийсэн. 2 давтамжийн сургалтанд нийт 124 хүн хамрагдсан. Гэр бүл төлөвлөлт сэдвээр 18-30 насны амбулаториор үйлчлүүлсэн 51, хэвтэн эмчлүүлсэн 23 иргэнд сургалт хийж, бүртгэл хөтлөн ажилласан. Мөн Эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар “Хүсээгүй жирэмслэлт” сэдвээр 9 зурагт хуудас, 8 видео шторкийг 4 удаагийн давтамжтай байршуулан ажилласан. Үзсэн хүний тоо 1058, хуваалцсан хүний тоо 16 байна.
28	Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслээр хангахад зориулагдсан зардлыг зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насныханд хүргэх	Зорилтод бүлгийнхэнд төлбөргүй хүргэсэн байна.	Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насныханыг “ЖСА” хэрэглээний эм хэрэгсэлээр хангасан. Дан хөхөөр хооллохын ач холбогдлын талаарх мэдээлэлийг төрсөн эхчүүдэд зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна. Мөн алслагдмал газар амьдардаг, эмзэг бүлгийн төрөх насны эмэгтэйчүүдэд эх баригч, Д.Бадамсүрэн багийн эмч нар хамтран хяналт тавьж, ЖСА-ын зөв зохистой хэрэглээний талаар эх баригч, нэма нар сургалт хийж шаардлагатай иргэдийг хамруулсан. ЖСА хэрэглээний талаарх сургалтыг 125 эмэгтэйчүүдэд орсон.ЕБС-ийн дотуур байрны охидод их эмч Б.Хоролмаа Нэма И.Ууганбаяр

1	2	3	4
			нар охидын ариун цэвэр сэдвээр сургалт хийсэн. Сургалтанд 27 охид хамрагдсан. Жирэмсэлтээс сэргийлэх эм хэрэгсэлийн талаар эх баригч, нэма нар 21 эмэгтэйд сургалт хийсэн.
29	Жендерийн үзэл баримтлалын талаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэгч нарт сургалт явуулах	Сургалт явуулсан байна.	Жендерийн үзэл баримтлалын талаар эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэгч эмч сувилагч нарт сургалт явуулсан б19 эмч ажилчид сургалтанд хамрагдлаа.
30	Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох судалгааны дүнгээр ядуурлын шугамаас доогуур орлоготой өрх, иргэнийг нийгмийн халамжийн хөтөлбөрт үргэлжлүүлэн хамруулах, шаардлагатай тусламж, үйлчилгээг хүргэх	Зорилтот бүлгийн иргэдийг халамжийн хөтөлбөрт хамруулсан байна.	Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэл хүргэж 1 иргэний төслийг ХХҮГ-т хүргүүлсэн. - Уул уурхайн Эрдэнэмонгол ХХК-ны "Баян хөндий төсөл"-ийн талбайд 7 иргэнийг ажиллуулан түр ажлын байраар хангасан. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжинд давхардсан тоогоор 322 иргэнд 227 сая орчим төгрөг зарцуулсан. Олон нийтийн оролцооны өдрийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдийг хамруулан 210,0 төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн. Өрхийн амьжиргааны түвшингээ дахин үнэлүүлэх 1 өрхийг судалгаанд хамруулж дахин үнэлгээ хийсэн ба малжуулах арга хэмжээний санхүүгийн дэмжлэгт хамруулан 8 сая төгрөгийн мал олгосон.
Долоо. Хүний эрхийн үндэсний комиссын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр			
31	Ерөнхий боловсролын сургуулийн дунд ангийн сургалтын хөтөлбөрт туссан хүний эрхийн боловсролын агуулгыг амжилттай хэрэгжүүлэх	Хүний эрхийн боловсрол олгох хичээлийн агуулгыг нутагшуулж, амжилттай хэрэгжүүлсэн байна.	Нийгмийн ухааны багш 3-р улирлаас эхлэн 7,8,9-р ангийн нийт 112 сурагчдад хүний эрхийн талаар нэгж хичээлийг зохион байгуулсан. Мөн "Аутизм" болон "авлига гэж юу вэ" сурагчдын дунд постер хийх

1	2	3	4
			уралдаан зарлаж, Постерийг Шинэжинст сумын ЕБС гэсэн фэйс группд байршуулан, нийт эцэг эх, асран хамгаалагч, сурагчдад таниулж ажилласан байна.
32	Хөдөлмөрийн тухай хуульд туссан ажлын байрны бэлгийн дарамтыг хориглохтой холбоотой журам зохицуулалтыг сурталчилан таниулах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах	Төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна.	Хөдөлмөрийн тухай хуулиар төрийн албан хаагч ард иргэдэд 12 сард сургалтыгн зохион байгуулж нийт 53 иргэн хамрагдсан байна.
33	"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ", "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ"-ийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх	Арга хэмжээнд малчид, залуучууд хамрагдсан байна.	Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээнд 11 өрхийн материалыг хүргүүлэн арга хэмжээнд хамруулан 88 сая төгрөгийн дэмжлэг олгосон. -Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээний зарыг цахим сайтад байршуулсан.

ХЯНАСАН/
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА  Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН,
МЭРГЭЖИЛТЭН  Ц.НАРАНЦЭЦЭГ